Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага ба тайлант онд Алтай сумын Засаг даргын харьяа байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд 2024 онд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Алтай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/59 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох  бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 214.6 сая төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 111.8 | 216.1 | 104.3 |
| Авлага | 205.5 | 167.8 | -37.7 |
| Бараа материал | 107.3 | 107.3 | 0.0 |
| Үндсэн хөрөнгө | 3827.5 | 3975.5 | 148.0 |
| **Нийт хөрөнгө** | **4,252.06** | **4,466.64** | **214.58** |
| Өр төлбөр | 7.4 | 82.0 | 74.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4244.6 | 4384.6 | 140.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,252.06** | **4,466.64** | **214.58** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгө, авлага,   үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад  өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 216.0 сая төгрөг болж, оны эхнээс 104.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Кассад байгаа бэлэн мөнгө** | - | - | - |
| **Банканд байгаа бэлэн мөнгө** | **111.78** | **216.06** | **104.28** |
| **Төгрөг** | **111.78** | **216.06** | **104.28** |
| Төрийн сангийн харилцах | 111.78 | 216.06 | 104.28 |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0 | 0 | 0.00 |
| **Дүн** | **111.78** | **216.06** | **104.28** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Орон нутгийн ерөнхий орлогын данс 98.4 сая, ОНХС-гийн данс 22.9 сая, Хоршоо хөгжүүлэх сан 94.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 205.5 сая төгрөг болж, өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 1.0 | 4.2 | 3.2 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.1 | 1.7 | 1.6 |
| **Зээлийн авлага** | **204.4** | **161.9** | **-42.5** |
| Хувь хүмүүст олгосон зээл | 204.4 | 161.9 | -42.5 |
| **Дүн** | **205.5** | **167.8** | **-37.7** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр буурсан нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 42.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Тайлант онд ажиллагчтай холбоотой авлага 3.2 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 1.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар авлага данстай холбоотой зөрчил гараагүй.*
- *ЗТТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан хаагчдад олгосон урьдчилгааны тооцооноос 0.9 сая төгрөгийг дутуу суутгаж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй орхигдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.*

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 107.25 сая төгрөг болж, оны эхнээс 0.03 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **7.54** | **7.51** | **-0.03** |
| Эм боох материал | 7.54 | 7.51 | **-0.03** |
| **Хангамжийн материал** | **99.7** | **99.7** | **0.00** |
| Аж ахуйн материал | 10.9 | 10.9 | **0.00** |
| Бусад хангамжийн материал | 88.9 | 88.9 | **0.00** |
| **Дүн** | **107.27** | **107.25** | **0.03** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Бараа материалын данс үлдэгдлийн 93 хувь нь хангамжийн материал байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Алтай сумын ЕБС нь бараа материалын тайланг хугацаанд гаргаж тайлагнаагүй, жилийн дүнгээр нэгтгэж тайлагнаж ирсний дээр тайлант онд сургуулийн хэрэгцээнд зарцуулсан 11,246.5 мянган төгрөгийн шатахуун, 20,505.7 мянган төгрөгийн хичээл практик, 9,791.2 мянган төгрөгийн аж ахуйн зардлын зарцуулалтад зохих журмаар хяналт тавьж ажиллаагүй, шатахуун олгосон жагсаалт үйлдээгүй, ямар ажлаар хаашаа явсан нь тодорхойгүй, шатахуун хүлээн авсан хүний жагсаалт үйлдээгүй, хичээл практикийн зардлын захиалгын нэгтгэл хийгээгүй, хичээл практик, аж ахуйн зардлын тараалтын жагсаалтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, бараа материалын тайланг сараар нэгтгэж гаргаагүй, худалдан авалтын төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй, хоолны болон үдийн цайны зардлын нийт төсөвт тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй, шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийсэн зөрчлүүдийг арилгах талаар зөвлөмж өгөгдсөн.*

*Алтай сумын ЭМТ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар тайлант хугацаанд батлагдсан 48,299.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тээвэр шатахуун худалдан авалт хийхдээ худалдан авалтын төлөвлөгөө боловсруулаагүй, шууд худалдан авалт хийсэн тул зөвлөмж өгөгдсөн.*

*Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн.*

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,203.8 сая төгрөг болж, өмнөх оноос 273.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **4,919.95** | **4,919.95** | **2,742.94** |
| Барилга, байгууламж, орон сууц | 1279.9 | 1287.9 | 8.0 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 247.7 | 408.7 | 161.1 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 442.0 | 506.2 | 64.2 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 43.4 | 52.2 | 8.9 |
| Зам, гүүрийн байгууламж | 2,774.92 | 2,794.8 | 19.9 |
| Бусад үндсэн хөрөнгө | 131.7 | 142.5 | 10.9 |
| Ном | 0.4 | 0.4 | 0.0 |
| **Биет бус хөрөнгө** | **10.2** | **10.2** | **1.4** |
| Программ хангамж | 3.3 | 3.3 | 1.4 |
| Бусад биет бус хөрөнгө | 6.9 | 7.7 | 0.8 |
| **Дүн** | **4,930.13** | **5,203.8** | **273.7** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Үндсэн хөрөнгийн данс нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ЗТТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого, бүртгэл, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, 160.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогод аваагүй, нярав нь 3.9 сая төгрөгийн бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалын орлого, зарцуулалтын тайланг гаргаагүй тул албан шаардлага өгсөн.*
- *ЕБСургууль нь нийт 23,990.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийсэн тул зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдөн.*
- *Соёлын төв нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, багаж, техник хэрэгслийн зардлаас 8,823.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авч, төрийн цахим худалдан авалтын журмыг зөрчсөн тул зөрчлийг арилгаж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн.*

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст 82.0 сая төгрөг болж, 74.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/ сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Өглөг** | **7.4** | **82.0** | **74.6** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 1.7 | 5.4 | 3.7 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | | **6.1** | **6.1** |
| **Бусад өглөг** | **5.7** | **70.4** | **64.7** |
| Байгууллагад төлөх өглөг | 5.7 | 70.4 | 64.7 |
| **Дүн** | **7.4** | **82.0** | **74.6** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Оны эхэнд сумын ЗДТГ-ын ажилчидтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн 1.7 сая төгрөгийн өглөгтэй байсан нь тайлант онд 3.7 сая төгрөгөөр нэмэгдэж 5.4 сая төгрөгийн өртэй гарсан байна. ЗДТГ нь шатахууны зардалд 2.3 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан эмийн 3.8 сая төгрөгийн, нийт 6.1 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөгтэй гарсан байна.

Орон нутгийн хөгжлийн сан оны эхэнд байгууллагад төлөх 5.7 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 22.8 сая төгрөгөөр нэмэгдэж 28.5 сая төгрөгийн өглөгтэй гарсан. Сумын ЗДТГ байгууллагад төлөх өглөг 23.2 сая төгрөгийн, хувь хүмүүст төлөх 3.6 сая төгрөгийн, сумын ИТХ байгууллагад төлөх 11.5 сая төгрөгийн, нийт 70.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өртэй гарсан байна.

*Аудитын илрүүлэлт: Аудитаар өр төлбөртэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,244.6 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 2,660.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо*

*/ сая төгрөгөөр*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,244.6 | 4,466.6 | 139.97 |
| **Хуримтлагдсан үр дүн** | **3,548.26** | **3,688.22** | **139.97** |
| Өмнөх үеийн үр дүн | 887.29 | 3,548.26 | 2,660.96 |
| Тайлант үеийн үр дүн | 2,660.97 | 139.97 | -2,520.99 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 243.75 | 243.75 | 0.00 |
| **Дүн** | **4,244.6** | **4,466.63** | **139.97** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 2,357.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,001.5 сая төгрөгийг урсгал зардалд, 355.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Нийт зардлын 831.5 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 1,109.9 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 355.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 60.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,236.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 831.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 1,020.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 341.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 42.9 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвөөс авахаар төлөвлөсөн санхүүжилтээс 89.3 сая төгрөгийг дутуу авсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас орох үндсэн үйл ажиллагааны орлогыг 60.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 42.9 сая төгрөг оруулж, 17.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,184.7 сая төгрөг буюу 93 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт*

- *Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй.*
- *Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 оны 7 дугаар сард хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 1 албан хаагчид 7,761,400 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 776,140 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.*
- *Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 6 албан хаагчид 43.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 4.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон тул төлбөрийн акт тогтоож, Засаг даргын зөвлөхийн орон тоо бий болгож, 2.5 сая төгрөгийн төсвийг үргүй зарцуулсан зөрчилд зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.*
- *Сумын ЕБС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нягтлан бодогчид 1,471.0 мянган төгрөгийн балансын шагнал олгосон зөрчилд албан шаардлага, дотуур байрны хүүхдийн хоолны талоныг бичихдээ ахлах, бага, дунд бүлэгт сурдаг хүүхдийн тоогоор ангилаагүй нийт хүүхдийн тоогоор бичиж зөрчилд зөвлөмж өгсөн.*
- *Сумын Улаанхад багийн сургуулийн захирал, нягтлан бодогч нар жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 3,015.0 мянган төгрөгийн урамшуулал авч, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдсөн.*
- *Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсны урамшуулалд 4,486.0 мянган төгрөгийн урамшуулал олгож төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн тул албан шаардлага өгөгдсөн. Аймгийн Засаг даргын 2024 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн Б/01 тоот захирамжаар цэцэрлэгийн орон тоог 55 орон тоогоор баталснаас гүйцэтгэлээр 57 орон тоо буюу 2 галч орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 8.6 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан зөрчилд зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн.*

***<u>Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар</u>:***

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 42.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 221 дүгээр тогтоолоор Алтай сумын 2024 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 672.2 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 1,010.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 67 дугаар тогтоолоор Алтай сумын 2024 орлогын төлөвлөгөөг 672.3 сая төгрөгөөр батлаж, сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг анх батлаcнаас 393.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,065.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр тайлант онд 1,073.5 сая төгрөгийн орлого оруулж /ХХОАТ-ын буцаалтыг хассан дүнгээр/ орлогын төлөвлөгөөг 7.7 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 64.3 сая төгрөг олгосон байна.

*Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* *\/сая төгрөг/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| I.Татварын орлого | 1,058.5 | 1,063.5 | 5.0 | 101% |
| II.Татварын бус орлого | 7.3 | 9.9 | 2.7 | 136% |
| **Нийт дүн** | **1,065.8** | **1,073.5** | **7.7** | **101%** |

Орон нутгийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ХХОАТ-ын орлого, бусад татварын орлого болон татварын бус орлогууд давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Татварын орлогоос - Хувь хүний орлогын албан татвар нийт дүнгээрээ 19.9 сая төгрөгөөр давж биелсэн ба цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 57.4 сая төгрөгөөр тасарсан, үйл ажиллагааны албан татвар 71.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогын албан татвар 4.5 сая, хөрөнгө борлуулсны орлогын татвар 1.4 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Бусад татвар нийт дүнгээрээ 2.5 сая төгрөгөөр давж биелэн ба улсын тэмдэгтийн хураамж 4.7 сая төгрөгөөр, малын татвар 9.7 сая төгрөгөөр давж, газрын төлбөр 1.4 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 7.8 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 3.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрүүд болох ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 0.3 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 17.3 сая төгрөгөөр тасарсан байна

Татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлого 2.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 45.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 1,137.8 сая төгрөгийн татварын орлого оруулж, аймгаас 831.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч нийт 1,969.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,916.5 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 98.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

*Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:*

*\/сая төгрөг/*

| № | Байгууллагын нэр | 2024 оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүнгээр | хувиар |
| 1 | Сумын ИТХурал | 193.9 | 171.0 | (22.9) | 88.2% |
| 2 | Сумын ЗДТГазар | 1,100.8 | 1,035.6 | (65.2) | 94% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Хоршоог хөгжүүлэх сан | 60.0 | 0.15 | (59.85) | 0.25% |
| 4 | ОНХСан | 355.7 | 332.4 | (23.3) | 94% |
| | **Орон нутгийн дүн** | **1,710.4** | **1,539.1** | **(171.3)** | **90%** |
| 1 | Ерөнхий боловсролын 1-р сургууль | 363.6 | 362.4 | (1.2) | 99.8% |
| 2 | Улаанхад бага сургууль | 36.8 | 36.8 | - | 100% |
| 3 | Хүүхдийн цэцэрлэг | 110.2 | 110.2 | - | 100% |
| 4 | Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг | 16.5 | 16.5 | | |
| 5 | Соёлын төв | 72.2 | 72.2 | - | 100% |
| 6 | Эрүүл мэндийн төв | 47.4 | 47.4 | - | 100% |
| | **Тусгай шилжүүлгийн дүн** | **646.8** | **645.6** | **(1.2)** | **99.8%** |
| | **Нийт дүн** | **2,357.1** | **2,184.7** | **(172.4)** | **92.7%** |

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд нийт 2,357.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 2,184.8 сая төгрөгийн төсвийг зарцуулж 92.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 22.9 сая, ЗДТГ 65.2 сая, Хоршоог хөгжүүлэх сан 59.9 сая, Орон нутгийн хөгжлийн сан 23.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ЗДТГ 1,100.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 1,035.6 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардал 94 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ нь орон нутгийн төсвөөс 65.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

Сумын ИТХ 193.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 171.0 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж 89 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай, Хоршоог хөгжүүлэх сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн гүйцэтгэл 99.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээ 1.2 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 9.5 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 7.6 сая төгрөгийн нийтдээ 17.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 5.3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 11.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 31 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,680.5 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож 40.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатанд Алтай сумын ТТЗ-ийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,357.7 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцоход материаллаг байдлын түвшин 63.3 сая төгрөг байна

Энэ нь төлөвлөлтийн үе шатанд төлөвлөсөн материаллаг байдлын түвшнээс 23.1 сая төгрөгөөр их байгаа тул материаллаг байдлын түвшнийг аудитын явцад дахин шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 4 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад худалдан авах ажиллагааны төлөвлөгөө оруулаагүй, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг оруулаагүй, ТТЗ-ийн дараа жилийн төсвийн төсөл, хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайлангууд, санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 94.2% тул зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна дүгнэлээ.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн зөрчлийн дүнгээр зөвлөмж өгөв.*
- *Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансанд өр үүсгэсэн 38.1 сая төгрөгийн өр үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авахыг анхааруулав.*
- *Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансанд мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад хагас жил тутамд байршуулах санхүүгийн тайлан, аудит хийсэн санхүүгийн тайлан, 11.5 сая төгрөгийн өр үүсгэсэн 1 шийдвэрийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.2 хувь байсан тул зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.*
- *Сумын ЭМТ нь шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 68 удаагийн 1,260,040.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 65 удаагийн 1,240,665.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон тул зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн.*
- *Сумын Хоршоог хөгжүүлэх сангийн шилэн дансанд хагас жил тутам байршуулах санхүүгийн тайлангуудыг болон жилийн эцсийн аудитын тайланг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 94.3 хувьтай байгаа тул зөрчлийг арилах зөвлөмж өгөгдсөн.*

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан болон сумын төрийн сан, эргэлтийн эмийн сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1 ба 2 дугаар сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын тайланг түүвэрт хамруулж, Эргэлтийн эмийн сангийн тайланг санхүүгийн тайланд нэгтгэсэн.

Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 606.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 382.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж , 7.0 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 202.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгөгдсөн ба 14.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн.

Сумын бусад төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,150.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 769.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 9.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 1,371.9 сая төгрөгийг зөрчлийг арилгах 7 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

*Хүснэгт №9 Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл* */сая төгрөгөөр/*

| Д/Д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алтай сумын ЗДТГ | 15 | 567.8 | 10 | 355.8 | 2 | 6.2 | 2 | 202.9 | 1 | 2.6 |
| 2 | Алтай сумын ИТХ | 4 | 38.9 | 2 | 26.6 | 1 | 0.8 | | | 1 | 11.5 |
| 3 | Алтай сумын ОНХС | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Алтай сумын ХХС | 1 | | | | | | | | 1 | |
| | **ТТЗ-ийн харьяа байгууллагуудын дүн** | **20** | **606.7** | **12** | **382.4** | **3** | **7.0** | **2** | **202.9** | **3** | **14.1** |
| 1 | Алтай сумын ЕБС | 6 | 225.5 | 3 | 158.5 | | | 1 | 1.5 | 2 | 65.5 |
| 2 | Алтай сумын Улаанхад багийн сургууль | 9 | 614.1 | 8 | 611.1 | | | 1 | 3.0 | | |
| 3 | Алтай сумын ЭМТ | 1 | 1,289.0 | | | | | | | 2 | 1,289.0 |
| 4 | Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг | 3 | 13.1 | | | | | 1 | 4.5 | 2 | 8.6 |
| 5 | Алтай сумын Соёлын төв | 1 | 8.8 | | | | | | | 1 | 8.8 |
| | **Бусад байгууллагуудын дүн** | **19** | **2,150.5** | **11** | **769.6** | | | **3** | **9.0** | **7** | **1,371.9** |
| | **Дүн** | **39** | **2,757.2** | **23** | **1,152.0** | **3** | **7.0** | **5** | **211.9** | **10** | **1,386.0** |

*Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ*

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албанд дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1.Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

**Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар зөрчил[1] илрээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой болон харьяа төсвийн байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгсөн.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад ТТЗ-ийн дараа жилийн төсвийн төсөл, хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайлангууд, санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 94.2 хувьтай байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....*", 6 дугаар зүйлийн 6.1.3-т "*дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор*", 6.1.4-т "*жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор*", 6.1.5-д "*төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор* “, 7 дугаар зүйлийн 7.1-д “*Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ*” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуул-сан | | Буруу тусган илэрхийл-сэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ТТЗ-ийн харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа, зөрчил илэрсэн. | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **1** | | | | | | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дараа жилийн төсвийн төсөл, хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайлангууд, санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг байршуулаагүй байна. | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **1** | | | | | | 1 | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | | | | | | **1** | |